

# ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДҮГНЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭРЭГСЛҮҮД

ТОВХИМОЛ 6 ХҮҮХЭД ЗАЛУУСЫН ТУРШЛАГА,  
ЗӨВЛӨМЖ ЗӨВЛӨГӨӨНҮҮД



## ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДҮГНЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭРЭГСЛҮҮД

**ТОВХИМОЛ** ХҮҮХЭД ЗАЛУУСЫН ТҮРШЛАГА,  
ЗӨВЛӨМЖ ЗӨВЛӨГӨӨНҮҮД

6

**Хүүхдийг Ивээх Сан 120 гаруй улсад үйл ажиллагаагаа явуулдаг. Бид хүүхдүүдийн амь амьдрал, эрхийнх нь төлөө тэмцдэг. Бид хүүхдүүдийг боломж бололцоогоо эдлэхэд нь тусалдаг.**

Энэхүү гарын авлагыг Жерисон Лэнсдаун, Клейр Окейн нар бүтээв.

### Өмнөх үг

Гарын авлагыг бүтээхэд олон хүүхэд, залуус, агентлагууд хувь нэмрээ оруулж ажилласан билээ. Хүн бүрийн нэрийг энд дурдах боломжгүй тул хүлцэл өчөөд, ач тус хүргэсэн явдалд баярлаж талархсанаа илэрхийлье.

Агентлаг хоорондын туршилтын үйл явцыг хоёр жилийн хугацаанд хошуучлан залж ирсэн хорооны дараах нэр бүхий гишүүдэд талархлаа тусгайлан илэрхийлмээр байна: Кавита Ратна (Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судлаач), Алана Капелл (Хүүхдийн хүчирхийллийн эсрэг байнгын төлөөлөгчийн ажлын алба), Билл Бэдхам (“Оролцоо үр дүнгээ өгдөг”), Сара остерланд, Сара Стивенсон, Вера Гам, Элсбет Бо (План Интернешнл), Речэл Тарди Форгакс, Билл Бэл, Ханна Мета (Хүүхдийг Ивээх Сан), Мериам Крамер, Жудит Диерс (НҮБ-ын Хүүхдийн Сан), Филлипа Лей, Пол Стефенсон (Дэлхийн Зөн), Мөн Анна Краули, Жо Федэр, Триша Янг, Клейр Ханбури, Рави Каркара, Аннет Гиертэн, Моника Линдвалл. Туршилтын үйл явц болон Гана дахь олон улсын сургалт семинарт хамтран ажилласан үндэсний мэдээллийн агентлагууд, түүний дотор Нигер дахь “Хөдөлмөр эрхлэгч хүүхэд залуусан Африкийн хөдөлгөөн” байгууллагын Жеймс Боэн, Гбедзони Аконасу, Гифт Бралае Эжми, Габриел Семетон Ханж нарт, Энэтхэг дэх “Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн холбоо” ТББ-ын Рошини Нугехали, Анида Сампад нарт, Никарагуагийн ЦЭСЭСМА хөтөлбөрийн Нохеми Торрес, Харри Шиэр нарт болон Малавийн “Хүүхэд бүр” хөтөлбөрийн Люси Моррис, Брюселс Мугого, Энэтхэгийн NCN сэтгүүлийн Эдвин Жон, “Гватемалын төлөвлөгөө” хөтөлбөрийн Жоз Кампан, Хелен

Марализ, “Латин Америкийн төлөвлөгөө”-ний Сантиаго Девила болон Доминикан, Эквадор, Эл Салвадор, Гондурас, Парагвай дахь төлөвлөгөө хөтөлбөрийн ажилтнуудад, Сенегалын олон улсын төлөвлөгөөний Алис Берендс, Тогогийн төлөвлөгөөний Францис Салако, Ажакло Дофо Кафуй, Хүүхдийг Ивээх Сангийн Непал дахь салбарын Дев Але, Гурунг Девраж, Хүүхдийг Ивээх Сангийн Клейр Блэк, Ребека Лосон, Зои Девидсон, Гана дахь Дэлхийн Зөн байгууллагын Грегори Дери, Мери Аппая, Фаустина Тиета, Южин Атами, Сесилиа Андерсен, Филип Боаду, Дорис Аджоа Арко Тетте, Мозис Гбекле, Филипа Канза, Замби дахь Дэлхийн Зөн байгууллагын Манянд Чисенга, Лифуна Симуши, Игнатус Муфвидакуле, Дэлхийн Зөн байгууллагын Стелла Нкурума-Абабио, Жулиан Саймон нарт талархсанаа илэрхийлье. “Царс Сан” (Oak Foundation) –гийн хамт олонд, туршилтын үйл явц болон эдгээр товхимлуудыг бүтээх үйлсэд санхүүгийн туслалцаа үзүүлж, хүүхдийн дуу хоолойг хүргэх мэргэн аргуудыг санаачилж, өөрийн хувь нэмрийг өвөрмөц хэрнээ цаг үеэ олсон байдлаар хүргэж байсанд баярлаад баршгүй юм. “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоох” хөтөлбөрийн баг хамт олон, ялангуяа Жейн Варбуртон, Фассил Мариам, Анастасия Антопулос нарт талархалаа илэрхийлмээр байна. Хэвлэлийн ажилд тусалж дэмжсэн Хүүхдийг Ивээх Сангийн Рави Викремасингэ, Сю Макферсон, Барти Мепани нарт баярлалаа.

Англи хэлнээс орчуулсан: Н.Гантуяа, Б.Амарсайхан


Орчуулгын редактор: Э.Цолмон

Уг бүтээлийг анх 2014 онд Их Британийн Хүүхдийг Ивээх Сангаас хэвлүүлэв. 2015 онд Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрөөс Монгол хэлрүү орчуулан Дэлхийн Зөн Монгол ОУБ-тай хамтран хэвлүүлэв.

Энэхүү зургаан бүлэгт ном нь олон улсад зохиогчийн эрхээр хамгаалагдсан болно.

# ГАРЧИГ

|                  |    |
|------------------|----|
| Танилцуулга      | 1  |
| Нэгдүгээр хэсэг  | 3  |
| Хоёрдугаар хэсэг | 12 |



**Зураг: “Нийгмийн хөгжлийн асуудалд хүүхдийн оролцоонд мэдрэмжтэй хандах нь” Нигери улсын Хөдөлмөр эрхлэгч хүүхэд залуусын Африкийн хөдөлгөөний бүтээл**



# ТАНИЛЦУУЛГА

Дурдсан байгууллага бүр энэхүү арга хэрэгслийн багцыг 2011 – 2013 онд туршин хэрэглэхэд оролцсон. Энэхүү арга хэрэгслийн багцыг боловсруулахын тулд байгууллага тус бүр арга хэрэгслийн багцыг турших үед оролцож байсан хүүхэд, залуучуудтай семинар зохион байгуулж, тэдэнд дараах асуултыг тавьсан. Үүнд:

1. Арга хэрэгслүүдийг туршин ашигласан хүүхэд, залуучуудын туршлага, санал, сэтгэгдэл
2. Хүүхэдтэй ажиллах хамгийн оновчтой аргын талаар насанд хүрэгсдэд өгөх зөвлөмж
3. Хамтарч ажиллаж байгаа насанд хүрэгсдээс юу хүлээж болох талаар бусад хүүхэд, залуучуудад өгөх зөвлөгөө

Хүүхдүүдийн өгсөн бүх санал, шүүмжлэл, зөвлөмжийг Нигери улс дахь Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн нэгтгэж, энэхүү гурван хэсэг товхимол болгон эмхэлсэн.

## **1-р хэсэг – Арга хэрэгслүүдийг туршин ашигласан хүүхэд, залуучуудын туршлага**

Энэ хэсгийг хүүхэд, залуучууд арга хэрэгслүүдийн талаар болон оролцоот хяналт шинжилгээг хэрхэн ойлгож байгаа талаарх бодол сэтгэгдлээ хуваалцах хэрэгсэл байхаар боловсруулсан.

## **2-р хэсэг – Хүүхэд, залуучуудаас хүүхдийн оролцооны идэвхжүүлэгчдэд өгөх зөвлөгөө**

Энэ хэсэгт оролцоот үйл ажиллагааг идэвхжүүлэх сайн туршлага юунаас бүрддэг талаар насанд хүрэгсдэд хүүхэд, залуучуудаас өгсөн багц зөвлөмжүүдийг оруулсан.

## **3-р хэсэг – Хүүхэд, залуучуудын удирдамж: хамт ажиллаж байгаа насанд хүрэгсдээс юу хүлээж болох вэ**

Хүүхэд, залуучуудад зориулсан энэ хэсгийг хүүхдэд тохиромжтой хэлбэрээр боловсруулсан. Энэ хэсэг бол хүүхэд, залуучуудын оролцоот үйл ажиллагаанд идэвхжүүлэгчээр ажиллаж байгаа насанд хүрэгсдээс чанартай ажиллагааны үүднээс юу хүлээж болох талаар хүүхэд, залуучуудаас үе тэнгийнхэндээ илгээсэн зөвлөмжийн багц юм.

Санамж: зохистой тохиолдолд хүүхэд, залуучуудын хэлсэн үгийг хэвээр нь оруулсан боловч үзэл бодлоо илэрхийлсэн хүүхэд, залуучуудын үгийг шаардлагатай тохиолдолд найруулгын хувьд өөрчлөх буюу нэгтгэж оруулсан болно.



**Балба улс, Сүхпет дүүргийн хүүхдийн клуб**

ГЭРЭГ ДУРАГ, СЭЭДЭН ПИ/ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН

**ЭНЭТХЭГ УЛС ДАХЬ СААХАЛТЫН ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭНИЙ ЗАЛУУЧУУДЫН ЗАХИДАЛ****“Манай гарагийн хүүхдүүд ээ,**

Энэтхэг дэх хүүхдийн парламентын гишүүд бид та бүхэнтэй мэндчилж байна. Бид та нартай бүгдэд чинь хайртай. Бид өөрсдөдөө их таалагдсан сонирхолтой туршлагаа та нартай хуваалцахаар шийдсэн юм. Энэ бол оролцоот хяналт, шинжилгээ, үнэлгээ (цаашид ХШҮ гэх)–ний ажил юм. Хүүхдүүд өөрсдөө өөрсдөдөө туслахыг дэмждэг, түүний тулд хүүхдийн оролцоо хэдий сайн хэрэгжиж байгаа байдалд үнэлгээ хийдэг хүмүүс зугаатай арга, хэрэгслүүдийг зохиож, боловсруулсан байна.

Арга хэрэгслүүдийн нэр нь хүртэл сонирхолтой. Хөтөлбөрийн мөчлөгөөр аялах, 'Н' үнэлэлт, Цагариг хүрээний шинжилгээ, Ажиглалт, Хүүхэд өөрчлөлтийн шинжилгээний хүрээнд, Хөтөлбөрийн мөчлөгийн дагуу аялах, гэх мэт. Зарим нэр нь маш энгийн. Ваар ба чулуу, Бие зураглал гээд л. Хэрэглэхэд маш хялбар, бас их зугаатай, бид бүгдээрээ дуртай байсан. Тоглоом тоглож байна л гэсэн үг. Үнэндээ бүгд танин мэдэхүйн тоглоом байсан учраас бид нарын ойлголт гүнзгийрч, итгэлтэй болж, өөрсдийгөө сайнаар төсөөлдөг болсон.

Түүнчлэн бас бид өөрсдийн оролцооны хэлбэрийн үнэ цэнийг ойлгосон. Энэ төрлийн оролцоо бидний өсөлтийг дэмжсэн гэдгийг бид мэдсэн. Бас хүүхдүүд бид энэхүү оролцооны хэлбэрийн нөлөөгөөр хэрхэн бүр илүү өсөж болох байсныг ойлгосон.

Тэр бол хүүхдийн парламентаар дамжсан оролцоо юм. Бид эндээ Саахалтын Хүүхдийн Парламенттай. Хөрш саахалт 30 айлын хүүхдүүд энэхүү парламентын гишүүн байдаг. Саахалтын парламентын гишүүдийн хувьд бид нар ойр орчноо хариуцдаг. Бас ойр орчны хүүхдүүдэд, хүмүүст хэрхэн хамгийн оновчтой тусалж болохыг судалдаг. Бид долоо хоног тутам цугладаг.

Бид нар саахалтын сайд хүүхдүүдтэй. Бас Ерөнхий Сайд хүүхэд, Эрүүл мэндийн сайд хүүхэд, Хүний эрхийн сайд хүүхэд, Байгаль орчны сайд хүүхэд, Боловсролын сайд хүүхэд, гэхчилэн сайд нартай. Сайд бүр мань бидэнд юунд анхаарахыг сануулдаг. Бид түүнийг нь хэлэлцээд, шийдвэр гаргаад, арга хэмжээ авдаг.

Бид та нартай хуваалцах олон амжилтын түүхтэй. Бид нар сургууль завсардсан болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг сургуульд нь эргүүлж оруулсан. Хүүхдийг эрт гэрлүүлэхийг таслан зогсоосон.

Бид тосгодыг гудамжны шинэ гэрэл, автобусны маршрут, цэцэрлэгийн шинэ барилга, номын сантай болгосон. Нэг газар бид бүр 100000 долларын өртөгтэй гүүр бариулсан. Саахалтын парламентаасаа бид тосгоны хүүхдийн парламент үүсгэж, дараа нь дүүргийн хүүхдийн пдарламент, муж улсын хүүхдийн парламент байгуулсан. Манай Тамилнаду–Пондичерри муж улсын хүүхдийн парламент 2009 онд хүүхдийн эрхийн төлөө хүүхдээр удирдуулсан шилдэг байгууллагаар шалгарсан.

Бид дээрх арга хэрэгслийг ашиглан оролцоот хяналт шинжилгээний үйл ажиллагаа явуулсан. Ингэхдээ хүүхдийн парламент ажиллуулж байгаадаа их баяртай байсан. Эдгээр дасгалыг ажилласнаараа бид хүүхдийн парламентынхаа ач холбогдлыг илүү гүнзгий ухаарсан.

Дасгал, арга хэрэгсэл бүхэн хүүхдийн парламентууд биднийг илүү үр дүнтэй оролцогчид байхад тусалсан олон хэлбэрийг ойлгуулсан. Бид бас хэрхэн оролцоогоо хамгийн зөв аргаар сайжруулах талаар олж мэдсэн. Тийм учраас бид нар хүүхдийн парламентдаа бүр ч дуртай, сонирхолтой болсон. Бүр олон хүүхэд тэрхүү үр шимийг хүртээсэй гэж бодсон. Тийм учраас та нарыг манайхтай адилхан парламентад элсээрэй гэж уриалж байна. Хүүхдийн парламент бидний оролцооны индэр болж өгсөн, түүнгүйгээр оролцоо бидний хувьд хэцүү байх байсан. Бид эцэстээ дэлхийн хүүхдийн парламенттай болж, тэндээ бүгдээрээ уулзаж, энэ ертөнцийг хүүхдэд ээлтэй болгохын төлөө ажиллах хэрэгтэй. Дэлхийн хүүхдүүд нэгдэцгээе!”

# I–P ХЭСЭГ – АРГА ХЭРЭГСЛҮҮДИЙГ ТУРШИН АШИГЛАСАН ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТУРШЛАГА

Дэлхий дахины хүүхэд, залуучууд бид ХШҮ–ний арга хэрэгслийг ашигласан туршлага, сэтгэгдлээ та бүхэнтэй хуваалцаж байна. Энэ бүлэгт та бүхэн дараах зүйлсийн талаар мэдэж авна:

- Бид ямар арга хэрэгсэл ашиглаж үзсэн болон тэдгээрийн талаар бидэнд төрсөн бодол
- Энэ ажил дахь өөрсдийнхөө оролцооны талаар бидэнд төрсөн сэтгэгдэл
- Үйл ажиллагааны явцад бид юу сурсан тухай
- Төслийн хүрээнд бидний хийж чадсан гайхамшигтай зүйлс
- Энэхүү ажлын үрээр манай орон нутагт гарсан чухал, бас гайхамшигтай өрчлөлтүүд

**БИД ЯМАР АРГА ХЭРЭГСЭЛ АШИГЛАСАН БЭ?**

Бид олон янзын арга хэрэгсэл ашигласан, жишээлбэл:

- Ваар ба чулуунууд
- Шийдвэр гаргах бүдүүвч
- Хамгийн дорвитой өөрчлөлтийн тухай өгүүлэмж
- Алхам мөр
- Бие зураглал
- Асуулттай карт
- Асуумж судалгаагаар мэдээлэл цуглуулах.
- Хөтөлбөрийн мөчлөг – өөрсдийнхөө нөхцөл байдлыг, хүүхдийн байгууллагынхаа цаг үеийн ажлыг ойлгох, орон нутгийн олон нийт дотор бидэнд тулгардаг асуудлуудыг танин мэдэх
- Хүүхдээр хөтлүүлсэн аялал, ажиглалт
- Хөтөлбөрийн мөчлөгийн дагуу аялах
- “Н” үнэлгээ
- Цагариг хүрээний дүн шинжилгээг ашиглан тэгш ба тэгш бус хамарч байгаа байдлыг судлах
- Өөрчлөлтийн шинжилгээн дэх хүүхэд
- Өөртөө итгэлтэй байдлын түвшний оноо (өмнө нь ба дараа нь)
- Ярилцлага
- Фокус бүлэг
- Асуудлын модоор дүн шинжилгээ хийх
- Өөрчлөлтийн термометр
- Ажиглалт

Эдгээр арга хэрэгслийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг **Товхимол 5**–аас уншаарай.

## АРГА ХЭРЭГСЛҮҮДИЙН ТАЛААР БИДЭНД ЯМАР БОДОЛ ТӨРСӨН БЭ?

Зарим маань бидний ашигласан арга хэрэгслийн талаар бидэнд ямар бодол төрж байсан талаар шинжлэхээр ажилласан. Бидний туршлага, төрсөн бодол, сэтгэгдлийн талаар эндээс уншаарай ...

### ХӨТӨЛБӨРИЙН МӨЧЛӨГ

“Энэ дасгал бидэнд таалагдсан. Энэ дасгал нь бидэнд үйл ажиллагааны үе шат бүрийг дахин санаж бодоход тусалсан. Бид нар хүүхдийн парламентуудын цаг хугацааны мөчлөгийг яг л сонирхолтой тууж шиг шимтэн сонсож байсан. Бас бусад бүлгүүдэд амжилтаа ярьж танилцуулах боломж олдсон.”

(СОНС, Энэтхэг Улс)

### ХҮҮХДЭЭР ХӨТЛҮҮЛСЭН АЯЛАЛ

“Хүүхдээр хөтлүүлсэн аяллууд их сонирхолтой байсан. Бид нар тосгодоор явж ололт амжилтаа танилцуулж явлаа. Жишээлбэл, эргэж сургуульд нь оруулсан хүүхдүүд, бидний үйл ажиллагааны үрээр хоолны карт авсан өрхүүдийг таницуулсан”

(СОНС, Энэтхэг Улс)

### ХӨТӨЛБӨРИЙН МӨЧЛӨГӨӨР АЯЛАХ

“Энэ дасгалыг бид өөрчлөөд орон нутаг эсвэл сургуульд хэнийг ахлагч гэж үздэг, тэр хүний зургийг тавиад, бас зарим үг хэллэгийг илүү ойлгомжтой болгож өөрчилсөн.”

(Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн, Нигери Улс)

“Хөтөлбөрийн мөчлөгөөр аялах сонирхолтой ч, сургамжтай ч байсан. Оролцооны түвшнүүдийг хөтөлбөрийн үе шат бүрт үнэлэхийн тулд ‘хүүхдийг оролцуулдаггүй, ‘хүүхдүүдтэй зөвлөдөг, ‘хамтран ажилладаг’, ‘хүүхдээр удирдуулдаг’ гэсэн дөрвөн хэллэгийг бичсэн самбарыг нэг нэг хүүхдээр бариулсан. Хүүхдүүдийг хөтөлбөрийн үе шатуудын үеэр оролцоо ямар байсан талаар өөрсдийн бодолтой нийцсэн самбарын дэргэд очиж зогсохыг урьсан. Ихэнх тохиолдолд ‘хүүхдээр удирдуулдаг’ гэдэг нь олон байсанд хүүхдүүд бид баяртай байлаа.”

(СОНС, Энэтхэг Улс)

### ЯВУУЛЫН АЖИГЛАЛТ

“Нэг үйл ажиллагаанд хүүхдүүд өөр өөр тосгоноос ирсэн байсан тул бид явуулын ажиглалтыг төсөөллийн хэлбэрээр зохион байгуулсан. Аль нэг тосгоноос ирсэн хүүхдүүд өрөөн дотор алхаж, үйл ажиллагааныхаа үр дүнг төсөөлөн танилцуулж байсан. Энэ арга нь ч бас их сонирхолтой байна билээ. Бид бусдынхаа олон амжилтын тухай сонсоход таатай байсан. Түүнчлэн өөр өөрсдийнхөө тосгонд ч бас тэр туршлагыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл төрж байсан.”

(СОНС, Энэтхэг Улс)



“Н” үнэлгээний ажил, Малави Улс.



‘Ваар ба чулуунууд’ дасгал, Того улс.

### ТӨСӨӨЛЛӨӨ АШИГЛАХ

“Төсөөлөл: хүүхэд, залуучууд өөрсдийнхөө тосгон, орон нутагт үйл ажиллагаа явагдаж байгаагаар төсөөлөөд, тэдгээр үйл ажиллагаа нь хүүхдүүдэд ямар үр нөлөө үзүүлж байгааг төсөөлсөн.”

(Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн, Нигери Улс)

### “Н” ҮНЭЛГЭЭ

“Н” үнэлгээнд бяцхан өөрчлөлт хийсэн. Нэг зураас дээр нь давуу талыг үзүүлэхийн тулд дээшээ чиглэсэн сум нэмсэн, нөгөө зураас дээр нь сул талыг үзүүлэхийн тулд доош чиглэсэн сум нэмсэн. Хүүхдүүд маш олон давуу талыг нэрлэсэн, жишээлбэл түвшин бүр дэх эвсэл холбоод, НҮБ-тэй харилцаатай, нэгдмэл байдал, орон нутгийн захиргааны байгууллагуудын дэмжлэг гэх зэргийг нэрлэсэн.”

(Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн, Нигери Улс)

### ВААР БА ЧУЛУУНУУД

“Бид бас ‘Ваар ба чулуунууд’ дасгалыг ажиллаж, хүүхдийн оролцооны есөн шаардлагыг хэрхэн оноолсноо үзсэн. Нийт есөн шаардлагад хамгийн дээд тал нь 27 чулуу хэрэглэх байсан. Бидний дундаж 27.5 шош гарсанд бид баяртай байлаа.”

(СОНС, Энэтхэг Улс)

“Ваар ба чулуунууд дасгал бидэнд цаг хугацааны явцад бидний оролцооны чанар хэрхэн сайжирсныг харахад тустай байсан. Бас чулууны тоогоо хэрхэн тодорхойлдог нь бид нарт таалагдсан. Бас л оролцоот аргаар тодорхойлдог. Ойлгоход их хялбар. Бас хэрэгжүүлэхэд амархан, тэгээд зугаатай.”

(План Того)

“Бидэнд есөн үндсэн шаардлагыг ойлгох амаргүй байсан. Энэ арга хэрэгсэлтэй ажиллахад дөхөмтэй болгохын тулд бид нарт амьдралын жишээ татаж, хангалттай цаг зарцуулж тайлбарлаж өгөөрэй. “Хариуцлагатай” гэх мэт үгийг бид амархан ойлгохгүй байна аа!”

“Бид нарт стандартуудыг ойлгоход туслахын тулд тоглоом, жүжигчилсэн тоглолт ашиглаж болно шүү. Бас хүүхэд бүхнийг оролцуулахыг анхаараарай.”

(План Того)



## ЦАГАРИГ ХҮРЭЭНИЙ ШИНЖИЛГЭЭ

“Бид нар шаланд дээр цагариг хүрээний шинжилгээний бүдүүвч зураад тэгш буюу тэгш бус хамралтын байдлыг судалсан. Арван хоёр болон түүнээс дооших насны охид, хөвгүүдийн ихэнх нь цагариг дотор орсон нь тэд ихэнх үйл ажиллагаанд тогтмол оролцож байсан гэсэн үг. Хөвгүүдийн ихэнх нь “хааяа оролцсон, идэвхтэй оролцсон гэхдээ дандаа биш” гэсэн цагаригт орсон. Тэд янз бүрийн тайлбар өгсний дотор “тэр үед нь тосгонд байгаагүй, хичээлтэй байсан, ажилтай байсан” гэх мэт тайлбар өгсөн.

(СОНС, Энэтхэг Улс)

“Цагариг хүрээний шинжилгээгээр тэгш ба тэгш бус хамралтын байдлыг шинжлэх арга хэрэгслийг бид нар хөтөлбөрийн дараа, бас Алхам мөр дасгалаар сургууль, орон нутгийн хөтөлбөр дэх хүүхдийн оролцоог үнэлснийхээ дараа ажилласан нь бидэнд илүү хялбар байсан.”

(Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн, Нигери Улс)

## ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛД ОНОО ӨГӨХ

“Бид нар бас өөртөө итгэх байдлын оноот үнэлгээ хийсэн (өмнөх үе ба дараах үеийн). Тэгээд парламентуудынхаа үйл ажиллагаанд бүр ч сонирхолтой болсон.”

(СОНС, Энэтхэг Улс)

## БИЕ ЗУРАГЛАЛ

“Бие зураглалын дасгал хүүхдүүд бид нарт их талаагдсан. Биенийг дээрээс доош шугамаар хуваагаад хүүхдийн парламент дахь оролцоог “өмнөх” ба “дараах” байдлаар тодорхойлсон. Ингэснээрээ хүүхдийн парламентын нөлөөгөөр бид нарын бодол сэтгэлгээ, амьдралыг харах, сонсох, харилцах байдал, эрүүл мэнд, үйл ажиллагаа, хандлагад олон янзын сайн өөрчлөлт гарсныг мэдсэн.”

(СОНС, Энэтхэг Улс)



Бие зураглалын дасгал

## ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭН ДЭХ ХҮҮХЭД

“Хүүхдийн парламентаар бидний хэрэгжүүлсэн үйл ажиллагаа орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшний төрийн байгууллагуудад ямар үр нөлөөтэй байсан бэ? Бид өрх, орон нутагт, бас иргэний нийгэмд орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд ямар үр нөлөө хүргэсэн бэ? Бид нар үүнийг тодорхойлоход Өөрчлөлтийн шинжилгээн дэх хүүхэд гэдэг арга хэрэгсэл тус болсон. Бид нар бас төрийн ба иргэний нийгмийн түвшинд, бас үндэсний ба олон улсын хэмжээнд мэдээлэн сурталчилсан. Бид удирдагчидтай хэрхэн харьцсан, үндэсний ба олон улсын уулзалтуудад санаагаа хүргэсэн тухай өгүүлэмжүүд гаргасан. Жишээлбэл, манай муж улсын Ерөнхий сайд хүүхэд Нью-Йорк дахь НҮБ-ын Комиссын Эмэгтэйчүүдийн асуудлаарх 57-р чуулганы үеийн олон хуралдаануудад илгээмж хүргүүлсэн.”

(СОНС, Энэтхэг Улс)

## ХАМГИЙН ДОРВИТОЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ӨГҮҮЛЭМЖ

“Бидний хамаг бүтээлч сэтгэлгээг ажиллуулсан нь ‘Хамгийн дорвитой өөрчлөлтийн өгүүлэмж’ дасгал байсан. Бид Хүүхдийн парламентаараа хүрсэн ололт амжилтаа хамгийн сонирхолтой өгүүлэмжээрээ дүрсэлсэн.”

(СОНС, Энэтхэг Улс)

## АЛХАМ МӨР

“Бид нар орон нутагтаа хэрэгжүүлсэн хөтөлбөрийн мөчлөгийг зурах, шийдвэр гаргахад биднийг хэрхэн оролцуулсныг тайлбарлах хамгийн амархан арга хэрэгсэл юм байна гэж мэдсэн.”

(Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн, Нигери Улс)

## ШИЙДВЭР ГАРГАХ БҮДҮҮВЧ

“Бас бид нар ‘Шийдвэр гаргах бүдүүвчийг’ ажиллаж, шийдвэр гаргахад нь бид үгээ хэлэх хэрэгтэй 10 чухал чиглэлийг тодорхойлсон. Бас яг одоо шийдвэр гаргахад нөлөөлж байгаа арван хүнийг тодорхойлсон. Бид нар юу олж мэдсэн бэ гэхээр хаана л хүүхдийн парламент ажиллаж байна тэнд шийдвэр гаргахад хүүхдүүд үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх боломж их байна гэдгийг харсан.”

(СОНС, Энэтхэг Улс)

“Энэхүү арга хэрэгслийг ашиласнаар бид нар хүүхдийн асуудлыг шийдэхийн тулд ямар хүмүүстэй ажиллах хэрэгтэйгээ ойлгосон. Бас хэн нь хамгийн нөлөөтэй, хэн нь бага нөлөөтэйг ойлгоход хэрэг болсон. Энэ арга хэрэгсэл зөв шийдвэр гаргах, сайн ажил бүтээхэд тустай байсан. Бас дэндүү хүнд биш байсан учраас бид нарт таалагдсан. Бас шийдвэр гаргахын өмнө бодох хэрэгтэй гэдгийг ойлгуулдаг арга хэрэгсэл юм. Бас тоглоом шиг ажилладаг тул бид энэ дасгалыг ажиллахдаа зугаатай байсан.”

(План Того)

“Бид нар бас Шийдвэр гаргах халаасны бүдүүвчийг ашиглаад тодорхойлж чадахгүй байсан, хэцүү байсан зүйлүүдийг тодорхойлсон... Эрхэм хүндэт насанд хүрэгчид ээ ... Бид нар нөлөөлөхийг хүсэж байгаа нөхцөл байдлуудыг тодорхойлох амаргүй байсан шүү. Зарим шийдвэр нь бид нарт хамааралгүй, зарим нь буруу зорилгоор хүмүүст нөлөөлж магадгүй юм байна. Үйл ажиллагаанд нөлөөлж чадах хүнийг олохын тулд сайн идэвхжүүлэгч хэрэгтэй юм байна. Нөлөө бүхий хүнийг тодорхойлж чадахгүй бол бид нар буруу хүнд нөлөөлөхөөр цаг хүчээ зарцуулж магадгүй. Энэ арга хэрэглийн нэр нь ч гэсэн хэцүү, тогтооход амаргүй юм.”

(План Того)



## ЭНЭ ҮЙЛ АЖИЛЛАГААГААР БИД ЮУ СУРСАН БЭ?

“Бид нар ээж аавдаа, асран хамгаалагчдадаа, төрийн байгууллагын дарга нарт, орон нутгийн удирдагчдад, бас орон нутгийн насанд хүрэгсдэд ч гэсэн өөрсдийгөө илэрхийлэх маш олон арга байгааг олж мэдсэн. Ингэхдээ манай оролцоо хүүхдүүдэд нөлөөлдөг асуудлуудаар шийдвэр гаргахад ямар их тустай, ач холбогдолтой болохыг бид нар харуулдаг. Асуумж ашиглан хүмүүсээс юм асуух, ярилцлага авах нь ч бас бид нарын оролцоог бидэнд нөлөөлдөг үйл хэрэг, шийдвэртээ баталгаажуулахыг хэлж өгөх арга юм байна. Ингэхийн тулд бас судалгаа хийж, хүүхдэд нөлөөлдөг аливаа асуудлыг шийдвэрлэж, найз нар, гэр бүл, төрөл садангуудаасаа тэдний гэр, орчинд шийдвэр гаргахдаа хүүхдийг хэрхэн оролцуулдаг талаар асуудаг.”

(Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн, Нигери Улс)

“Ардчилал, төлөөлөл, хариуцлагын тогтолцоо гээд энэ олон үгийг бид нар ойлгодог болсон.”

(Энэтхэг Улсын Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Төлөө)

“Бид нар хэрхэн:

- Ажлынхаа үр нөлөөг хэмжихийг сурсан
- Цуглуулсан мэдээллээ ашиглаж орон нутгийн засаг захиргаандаа асуудал, нөхцөл байдлаа танилцуулах, тэдгээрийг шийдэхэд тэдний хариуг авахыг сурсан.”

(ХЭХТБ–ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс)

“Бид нар Хөтөлбөрийн мөчлөгийн шинжилгээ хийж байхдаа нөхцөл байдлын судалгаа, стратеги төлөвлөлтийн үеэр бид нар илүү оролцсоноо ойлгосон. Харин хэрэгжүүлэх, ХШҮ хийх үед нь бид нар бага оролцсон юм байна.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)

“Оролцооны есөн шаардлагын хамгийн том зөрчлийг дараах гэж бид нар олж тогтоосон:

1. Оролцоо хүндэтгэлтэй байх – манай орон нутагт “хүүхэд харагдаж байх ёстой, сонсогдох ёсгүй” гэсэн итгэл хүчтэй байдгаас бид нар орон нутагт хүүхдэд нөлөөлдөг асуудлуудад оролцож чадахгүй байна гэдгийг мэдсэн.
2. Оролцоо тэгш хамарсан байх – хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оролцуулаагүй юм байна.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)

“Бидний оролцоо ихэнхдээ зөвлөлдөх, хамтран ажиллах түвшинд байсныг бид нар ойлгосон. Бид нар хөтөлбөрийн мөчлөгийн үе шат бүхэнд оролцмоор байна. Бид нар хүүхдийн дуу хоолойг сонсдоггүй, хардаг ч үгүй уламжлалтай орон нутагт амьдардаг учраас бид оролцож байхдаа бас хамгаалагдаж баймаар байна.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)

## ОДОО БИД НАР ЯМАР ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДСЭН БЭ?

“Бид нар энэ бүх уулзалт, цуглааны үеэр тавьсан илтгэлүүдээрээ бахархаж байна.”

(ХЭХТБ–ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс)

“Бидний зарим мань алс холын тосгоноос ирсэн. Бид танихгүй хүмүүстэй ерөөсөө харьцаж байгаагүй. Бид нар гадны хүн харагдвал зугтдаг байсан. Энэ үйл ажиллагаанд оролцсоныхоо дараа бид нар харин их итгэлтэй боллоо. Одоо бид хүүхдэд хамааралтай ямар ч асуудлаар ямар ч насанд хүрсэн хүнтэй ярилцаж, хэлэлцэж чадах болсон.”

(ХЭХТБ–ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс)

“ХШҮ–ний ажил маш сонирхолтой юм байна, бид нар оролцож, энэ ажлын нэг хэсэг нь болж байсандаа таатай байна. Манай сургуулийн зохиодог ажлаас ч илүү сонирхолтой юм байна шүү.”

(ХЭХТБ–ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс)

“Бид орон нутгийнхаа насанд хүрэгсэдтэй, бас орон нутгийн захиргаатайгаа өөрсдийн санал бодол, асуудлыг ярилцаж сурсан.”

(ХЭХТБ–ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс)

“Энэ үйл ажиллагаа бидэнд сайхан байсан. Бид нар чадавхижсан, бас хүүхдийн оролцооны өөрсдийн арга хэлбэрээр бахархсан. Тэр арга хэлбэр мань Саахалтын Хүүхдийн Парламент юм [www.childrenparliament.in](http://www.childrenparliament.in).”

(СОНС, Энэтхэг Улс)

“Бид нар хүүхдийн эрхийн тухай мэдлэгтэй болсноор чадавхи нэмэгдсэн. Бид нар хүчирхийллийн талаар үгээ хэлэх итгэл, зоригтой болж байна.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)

“Арга хэрэгслүүдийг хүүхдэд тохиромжтой, зугаатай хэлбэрээр зохиож, бид нарын хамгийн сайн ойлгох хэлбэрээр тайлбарласанд их баярлаж, бахархсан.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)

“Бид нар ярьсан зарим зүйл, хувийн бэрхшээл, тэмцлийнхээ тухай ярьсан зүйлийн нууцыг мань хадгалаасай гэж хүсэж байна.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)

“Манай орон нутгийн ихэнх насанд хүрэгсэд бид нарт итгэж, бид нарыг сонсдоггүй, хүүхдэд хамаатай шийдвэр гаргахдаа үнэн зөв мэдээлэл ашигладаггүйд нь бид нар гунигтай байна.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)





Пакистаны Пешавар дүүргийн төөрсөн хүүхдүүдэд зориулсан сургалтын түр байран дахь охид

### ЭНЭ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИД НАРЫН ХИЙСЭН ГАЙХАЛТАЙ ЗҮЙЛС

ХЭХТБ-ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс:

- Бид энэ хугацаанд орон нутгийн захиргааг ямар нэг хэмжээнд бидний асуудлаар бидэнд тайлагнадаг, бидний өмнө хариуцлага хүлээдэг болгож чадсан.
- Бид нар үйл ажиллагаанд оролцсон туршлагаа ТВ-ийн хүүхдийн нэвтрүүлгээр хуваалцаж чадсан, бас орон нутгийн захиргааны төлөөлөгчид болон Энэтхэг Улсын Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Төлөө байгууллагын гишүүдтэй хүүхдүүдийн асуудлын тухай уулзахдаа туршлагаа хуваалцсан.
- Бид нар энэ хугацаанд орон нутгийн захиргаагаа хүүхдийн асуудлаар тусгай хурал хийх, түүндээ хүүхдийн төлөөлөл оруулахаар болгож чадсан.
- Бид нар орон нутгийн захиргаанд танилцуулсан асуудлынхаа тоог улаан туузаар төлөөлүүлдэг, туузнуудаа захиргааны байшингийн өмнө модонд уяж, тэд нарт өдөр бүр үүгээрээ хүүхдийн асуудлуудыг сануулж байх болсон. Тэд нар хүүхдийн асуудлуудыг шийдвэрлэх тоолонд нь нэг улаан туузыг модноос тайлж аваад, бидний асуудлын хэдийг нь орон нутгин захиргаа мань шийдэж өгснийг харуулж байсан. Энэ үйл ажиллагааг хойшид ч бас үргэлжлүүлнэ. Одоо бид нар орон нутгийн захиргаагаа хүүхдийн асуудалд илүү мэдрэмжтэй болгож сурсан. Аав ээж нар мань, орон нутгийн хүмүүс ч бас энэ үйл ажиллагаагаар бид нар асуудлаа шийдэж байгааг харж байгаа.
- Бид нар бусад хүүхдүүдийг байгууллагадаа элсүүлж чадсан.
- Энэ хугацаанд бид нар бас зарим өөр газар очиж үзсэн.

“Бид нарын зорилго: хүүхдийн парламентын үр нөлөөг хүүхдүүдээр өөрсдөөр үнэлүүлдэг байх.”

(СОНС, Энэтхэг Улс)

### ЭНЭ АЖЛЫН ҮРЭЭР МАНАЙ ОРОН НУТАГТ ГАРСАН ГАЙХАМШИГТАЙ ЧУХАЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

“ХШҮ-ний арга хэрэгслүүдийг олон орнуудад хүүхэд, залуучууд шийдвэр гаргахдаа ашиглахад оролцсоноор ихээхэн эерэг өөрчлөлт гарсан байна. Энэ бол хүүхдэд хамааралтай бүх асуудлаар шийдвэр гаргахад хүүхдийн оролцоог дэмжих ухуулга нөлөөллийн нэг арга хэлбэр юм. Эдгээр арга хэрэгслийг ашиглан орон нутаг, сургууль, хүүхдэд ээлтэй байруудад хэрэгжүүлсэн төсөл дэх хүүхдийн оролцоонд ХШҮ хийхэд хүүхэд, залуучууд гол үүрэг гүйцэтгэж байна.”

(Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Хөдөлгөөн, Нигери Улс)

“Орон нутгийн захиргаад хүүхдийн асуудалд илүү анхааралтай ханддаг болж байна. Бид нарын асуудлуудад тэд шийдэл олох тухай орон нутгийн насанд хүрэгсэдтэй ярилцаж, хэлэлцдэг болсон.”

(ХЭХТБ-ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс)

“Бид нарын зарим санал, жишээлбэл орон нутаг дахь аюултай газруудад анхааруулах тэмдэг өлгөх тухай санал мань тэдгээр аюултай цэгийн ойролцоо явах хүмүүст тустай юм. Орон нутгийн захиргаа мань бидний саналыг дэмжиж, борооны улирлаар аюултай цэг гэж мэдэгдсэн газруудад анхааруулах тэмдэг тавьсан. Бас тэр цэгүүдийг тойруулаад хамгаалах хашлага, хашаа барих тухай ч ярьж байгаа.”

(ХЭХТБ-ын дэмжлэгтэй хүүхдийн байгууллага, Энэтхэг Улс)

“Хүүхдүүдийн үйл ажиллагаа ахмад удирдагчдын анхаарлыг татсан. Ахмадууд мань:

- хүүхдийг гэрлүүлэх гэх мэт хортой уламжлалт зан үйлд хуучин шигээ тэвчээртэй хандахаа больсон
- хүүхдийн эрхийн талаар мэдээлэл өгснөөр орон нутгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүүхдийг дэмжиж ажиллахад дайчлан оролцуулдаг болсон.

Түүнчлэн бас Боловсролын газар, Цагдаагийн дэргэдэх Хохирогсдыг дэмжих нэгж, Нийгмийн халамжийн хэлтэс цаг ямагт хүүхдийн эрхийг хамгаалхын төлөө илүү эртэй ажилладаг болсон.”

(Дэлхийн Зөн, Замби Улс)



Хулна дахь хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн төв, Бангладеш Улс.

ГЭРЭЛ ЗУРАГ: ПАТРИЦИЯ КАПОЛЕОГ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН



## 2-Р ХЭСЭГ – ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДААС ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ИДЭВХЖҮҮЛЭГЧДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Хүүхэдтэй ажиллах хамгийн оновчтой аргын талаар насанд хүрсэн идэвхжүүлэгчдэд зөвлөмж өгөхийг хүүхэд, залуучуудаас хүссэн. Тэдний өгсөн бүх зөвлөгөөг товхимлын энэ хэсгээс уншина уу.

1. План Того болон Замби Улс дахь Дэлхийн Зөн байгууллагатай ажилладаг хүүхдүүд зөвлөмжөө танилцуулах арга болгож 'НҮБ-ын ХЭК-ийн Хүүхдийн үр дүнтэй, ёс суртахуунтай оролцооны үндсэн есөн шаардлагыг' ашигласан байна.
2. Энэтхэг Улсын Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүдийн Төлөө (Concerned for Working Children) байгууллагын дэмждэг хүүхдийн байгууллагууд болон Сахалтын Олон нийтийн сүлжээний хүүхдүүд, Нигери Улсын Африкийн Хөдөлмөр Эрхлэгч Хүүхэд Залуучуудын Хөдөлгөөн (AMWCY) насанд хүрэгсдэд өгөх ерөнхий зөвлөгөө, санамжуудыг нэгтгэсэн юм.
3. Эцэст нь Гана Улс дахь Дэлхийн Зөн байгууллага, Нигери Улс дахь АХЭХЗХ-ний хүүхдүүд 2013 оны 5 сард Гана Улсад уулзаж, зөвлөмжүүдээ хэлэлцсэн.



**Хүүхдийг Ивээх Сангийн Дэлхийн дахины зөвлөлийн гишүүдийн семинар.**

### PLAN TOGO БОЛОН ЗАМБИ ДАХЬ ДЭЛХИЙН ЗӨН БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДҮҮДИЙН ЗӨВЛӨГӨӨ

#### ҮНДСЭН ШААРДЛАГА 1: ОРОЛЦОО МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАДАГ, ИЛ ТОД БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгчид ээ, Та бүхэн хүүхдэд хамааралтай асуудлаар шийдвэр гаргахдаа хүүхдийг оролцуулж байгаарай!

- Болохгүй зүйлс:
  1. Аль үйл ажиллагаанд клубын аль гишүүд орохыг бид нартай зөвлөлдөхгүй шийдэх;
  2. Үйл ажиллагаа бүхэнд өмнө нь орж байсан хүүхдүүдийг л дахин дахин оролцуулж бусдад нь хардалт төрүүлэх
- Насанд хүрэгчид ээ, зорилгодоо хүрэхдээ бид нарыг битгий төөрөгдүүлээрэй. Тухайн төсөл, үйл ажиллагаагаараа Та бүхэн чухам юунд хүрэхийг хүсэж байгаагаа бидэнд үнэн зөв мэдээлж байгаарай. Биднийг сонсож байгаарай. Бидэнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгож байгаарай.

#### ҮНДСЭН ШААРДЛАГА 2: ОРОЛЦОО САЙН ДУРЫН ҮНДСЭН ДЭЭР БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгсэд ээ, хүүхдүүдэд чөлөөтэй оролцох боломж олгоорой. Хүүхэд үйл ажиллагаанд оролцохыг хүсэхгүй байвал битгий оролцуулах гэж албадаарай.

- Бидэнд оролцоход тааламжтай биш байгаа, эсвэл ердөө л оролцохыг хүсэхгүй байгаа үйл ажиллагаанд биднийг битгий хүчлэн оролцуулаарай. Бидний "тийм", "үгүй" гэсэн хариултыг хүлээж аваарай.
- Тухайн үйл ажиллагаанд оролцох нь тухайн хүүхдэд өөрт нь сайн гэж Та өөрөө итгэж байвч хүсэхгүй байхад нь хүчээр битгий оролцуулаарай!

#### ҮНДСЭН ШААРДЛАГА 3: ОРОЛЦОО ХҮНДЭТГЭЛТЭЙ БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгсэд ээ, хүүхдүүдийг үйл ажиллагаанд оролцуулахаар урихдаа хэзээ завтай байдгийг нь санаж мэдэж байгаарай!

- Насанд хүрэгсэд ээ, орон нутагтаа тустай зүйл санал болгож чадах хүмүүс гэдгийг мань санаж биднийг хүндэтгэж байгаарай.
- Өөрсдийн зохион байгуулж байгаа сургалт, хуралд биднийг оролцуулахын тулд битгий бидний хичээлийг таслуулаарай!

#### ҮНДСЭН ШААРДЛАГА 4: ОРОЛЦОО ХОЛБОГДОЛТОЙ БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгсэд ээ, бид сургалтад дуртай! Гэхдээ тухайн сургалт нь бид нарт холбогдолтой байх хэрэгтэйг анхаараарай!

- Бид нарт сөргөөр нөлөөлж болох ямар ч сэдвээр бид нарт сургалт битгий явуулаарай. Жишээлбэл галт зэвсэг ашиглах тухай сургалт бид нарт холбогдолгүй шүү.
- Бид нарыг оролцуулж байгаа үйл ажиллагаа, бид нарт өгч байгаа сургалтын материал бид нарт холбогдолтой байх хэрэгтэй шүү.

### ҮНДСЭН ШААРДЛАГА 5: ОРОЛЦОО ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгчид ээ, бид нарт зориулж зохион байгуулж байгаа бүх үйл ажиллагаа хүүхдэд ээлтэй, бүх хүүхдэд хүртээмжтэй байх хэрэгтэй шүү.

- Насанд хүрэгчид ээ, хүүхдийг насанд нь тохирсон үйл ажиллагаанд оролцуулж байгаарай. Ямагт бид нарт ойлгомжтой үг, хэлээр бид нартай ярьж байгаарай.
- Уулзалтуудыг хүүхэд бүрт хүртээмжтэй биш газарт битгий зохион байгуулаарай, бас хүүхэд бүхэн оролцож болох орон зайтай байхыг анхаараарай!

### ҮНДСЭН ШААРДЛАГА 6: ОРОЛЦОО ТЭГШ ХАМАРСАН БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгчид ээ, хүүхдүүд бие биеэ ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлж, нэг ч хүүхэд үйл ажиллагаанаас хасагдах нөхцөл үүсгэхгүй байхыг анхаараарай!

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үйл ажиллагаанд оролцуулахгүй орхиж болохгүй шүү!
- Хүүхэд бид нар насанд хүрэгчид Та бүхнийг биднийг хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байхыг хүсэж байна. Бас бид нарын хөгжлийн бэрхшээлтэй найз нар, өөр арьстан, угсаатан найз нарыг мань үйл ажиллагааны гадна битгий орхиосой гэж хүсэж байна. Бид нар бүгдээрээ оролцох тэгш боломжтой байх ёстой.

### ҮНДСЭН ШААРДЛАГА 7: ОРОЛЦОО НАСАНД ХҮРЭГСЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТАД ТҮШИГЛЭСЭН

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгчид ээ, бид нартай ажиллах насанд хүрэгчид бид нарыг дарамталахгүй, хүчирхийлэхгүй байх, сайн сургагдсан байх нөхцлийг хангаарай!

- Хүүхэдтэй ажиллаж байхдаа бие махбодын шийтгэл хэрэглэж болохгүй!
- Бид нарыг дуулгавартай байлгах гэж саваа мод, бусад аливаа эд юм хэрэглэж болохгүй!
- Хүүхэд бид нар насанд хүрэгчид Та бүхнээс эдгээр арга хэрэгсэл болон хүүхдийн оролцооны талаар бусад зүйлсийг бидэнд зааж байхдаа чадвартай, итгэлтэй байхыг хүсэж байна.

### ҮНДСЭН ШААРДЛАГА 8: ОРОЛЦОО ЭРСДЭЛД МЭДРЭМЖТЭЙ, АЮУЛГҮЙ БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгчид ээ, биднийг үйл ажиллагаанд оролцуулахаар авч явахдаа аюулгүй тээврийн хэрэгсэл ашиглаарай! Нэг хүүхдэд нэг суудал оногдохоор зохион байгуулаарай!

- Хариуцлагатай, сургалтад хамрагдсан, болгоомжтой жолооч ажиллуулаарай!
- Оролцооны үеэр бид нар аюулгүй байж, дарамт хүчирхийлэлд өртөх вий гэсэн айдасгүй баймаар байна.

### ҮНДСЭН ШААРДЛАГА 9: ОРОЛЦОО ХАРИУЦЛАГАТАЙ БАЙХ

**Илгээлт:** Хүндэт насанд хүрэгчид ээ, бид нарын байгууллагыг Та бүхэн хэрхэн, ямар хугацаанд дэмжих талаараа бид нарт маш тодорхой мэдээлж байгаарай.

- Бид нараас ямарваа зүйл асуусныхаа дараа бидэнд заавал эргэн мэдээлж байгаарай. Бидний санал бодол хэрхэн хэрэг болсныг бид нарт хэлж байгаарай?
- Та бүхнийг хүүхэд бид нартай ажиллаж байхдаа ил тод, шударга байхыг хүсэж байна.

### НАСАНД ХҮРСЭН ИДЭВХЖҮҮЛЭГЧДЭД ӨГӨХ ЗАРИМ ЗӨВЛӨМЖ ...

#### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ХҮҮХДҮҮДИЙН ТӨЛӨӨ БАЙГУУЛЛАГЫН ДЭМЖЛЭГТЭЙ ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГСӨН ЗӨВЛӨГӨӨ, ЭНЭТХЭГ УЛС

- Хүүхдүүд өөрийнхөө харьяалагддаг хүүхдийн байгууллагыг төлөөлөхөд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
- Хүүхдүүд хөгжим, жүжиг, спорт гэх зэрэг соёлын илэрхийллээс таашаал авах боломжтой байх хэрэгтэй.
- Өөрийгөө илэрхийлэх нь хүүхдүүдэд хэрэгтэй юу? Тэр нь хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх эрх. Тэр нь бас үзэл бодлоо илэрхийлэхэд нь хүүхдүүдэд тус болдог. Хүүхдүүд таашаал өгдөг спорт, тоглоомуудад оролцох боломжтой байх хэрэгтэй.
- Хүүхдийн байгууллагууд тогтмол цуглаж байх боломжтой байх хэрэгтэй. Энэ нь бие биеэсээ суралцах, эвийн хүчинд итгэхэд тустай.
- Орон нутгийн төрийн байгууллагын түвшинд хүүхдүүд насанд хүрэгчид болон төр захиргааны байгууллагатайгаа харилцах бүтэц байх хэрэгтэй.
- Бүх түвшний төрийн захиргааны байгууллагууд мөн хүүхдүүдийг хуралдаа урьж, тулгамдсан асуудлаа илэрхийлэхэд нь тусалдаг байх хэрэгтэй.
- Хүүхдүүдийн ар гэрийнхэн нь хүүхдийн оролцооны талаар мэдээлэлтэй байж, хүүхдээ санал бодлоо илэрхийлэхэд нь хэрхэн туслах талаар мэддэг байх хэрэгтэй.
- Хүүхдийн гэр бүлийн насанд хүрэгчид хүүхдийг сонсож, хувцас, гутал гэх зэрэг зүйлийг худалдан авч өгөхдөө ч сонголт хийх боломж олгодог байх хэрэгтэй.
- Хүүхдийн байгууллагуудыг ардчилал, оролцоо, хүний эрх, хүүхдийн эрх, төлөөлөл, байгууллага удирдах гэх зэрэг сэдвийн мэдээллээр хангадаг байх хэрэгтэй. Эдгээр нь байгууллага дотроо болон хүүхдийн асуудлаар шийдвэр гаргаж байгаа бусад үйл ажиллагаанд хэрхэн илүү утга учиртай оролцох талаар ойлгож, суралцахад хүүхдийн байгууллагуудад тустай байх болно.
- Хүүхдийн байгууллагуудыг шударга бус, хууль бус үйл ажиллагаа, дадал заншлыг эсэргүүцэх зарчмын тухай мэдээллээр хангадаг байх хэрэгтэй. Хүүхдүүд бас амьдралд нь нөлөөлдөг хууль бус үйл ажиллагааг эсэргүүцдэг байх хэрэгтэй.
- Хүүхдүүд боловсрол олж байгаа үйл ажиллагаандаа оролцдог байх хэрэгтэй.
- Хүүхдүүд орон нутгийн “байгаль орчныг хамгаалах” төлөвлөгөө боловсруулахад оролцож, байгаль хамгаалахад үүрэг гүйцэтгэх хэрэгтэй.



## ХӨРШИЙН СҮЛЖЭЭНИЙ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ӨГСӨН ЗӨВЛӨГӨӨ, ЭНЭТХЭГ УЛС

Хүүхдийн парламент, тэдгээрийн эвслийг байгуулах, бэхжүүлэхэд тусална уу!

- Та бүхнийг **бид нарын найз нөхөр** байгаасай гэж бид нар хүсэж байна.
- Та бүхнийг **битгий хичээл ангийн багш шиг байгаасай** гэж бид нар хүсэж байна.
- Та бүхнийг бид нарт заавал хариулт бүхнийг өгөөсэй гэхгүй. **Хариултыг өөрсдөө олох баяр бахдлыг эдлэх** боломжийг бидэнд олгоорой.
- Та бүхэн заримдаа чанга, тууштай байх хэрэгтэй байдгийг бид нар ойлгодог, бас талархдаг. Гэхдээ ихэнхдээ бид нар шиг байж, бид нарын түвшинд байж, бид нартай тоглодог байгаасай, бидний баясдаг зүйлд баясаж, бид нарт анхааралтай хандаж, бид нарын баяр хөөр, амжилт, тэмцэл, зовуурт нухацтай анхаарч байгаасай гэж хүсдэг.
- Битгий бидэнд сургамжлахаар өндөр сэнтийд суугарай. Бид нар шалан дээр сууцгаасан бол бас л адилхан **шалан дээр суугаарай**. Тэгвэл бид нар Та нарт итгэл төрнө.
- Та бүхэн хүүхдүүдэд анхаарал тавьдаг, **бид нарт хайртай** гэдгээ бидэнд ойлгуулаарай.
- Насанд хүрэгчид, бусад хүмүүс гадуурх цагаригт байхад бид нар дотуурх цагаригт байхдаа тааламжтай байсан. Ердийн үед насанд хүрэгсэд төвд байдаг. Харин энд бол өөр байсан шүү.
- Тийм ээ, бид нар суралцахыг хүсдэг. Гэхдээ суралцахыг битгий уйтгартай болгоорой. **Сонирхолтой, оролцоотой болгоорой**. Ингэвэл ХШҮ–ний арга хэрэгслүүд, үйл ажиллагаа сонирхолтой, зугаатай болно.
- **Хүүхэд бүрийн оролцоог хангаарай**. Зарим хүүхдүүд хэлэлцүүлгийн үеэр бүх л зүйлийг ярьж хэлэх хандлагатай, бас чадвартай байдаг. Энэ нь бусад хүүхдүүдийг хэлэх зүйлгүй болгож, оролцох ямар ч боломжгүй болгож орхидог. Тийм учраас хүүхэд бүрийг нэг удаа үг хэлэхдээ нэг л зүйлийг хөндөж хэлүүлээрэй. Хэлэгдэхгүй өнгөрсөн зүйл байвал хоёр дахь, эсвэл гурав дахь тойрогт нэмээд хэлж болно.
- Хөтөлбөр дундуураа бас **дуу, тоглоом, соёлын үйл ажиллагаа** оруулж өгөөрэй.



Валала дахь ХШҮ–ний төслийн суурь судалгааны хүрээнд фокус бүлэгт оролцож байгаа хүүхдүүд, Никарагуа Улс.

- Бид нар **суусан байр, байрлалаа өөрчлөх боломжтой** байсан нь бид нарт таатай байсан.
- Бид нараар зураг зуруулах, жүжигчилсэн тоглолт тоглуулах гэх зэрэг зүйл хийлгээрэй. Тэгвэл хөтөлбөр бидэнд бүр ч их тааламжтай байх болно.
- Та бүхэн **шаардлагатай материалтайгаа, бэлтгэлтэй ирэхэд** бид нар баяртай байдаг. Жишээлбэл дэлгэмэл цаас, харандаа, бөмбөг, үр, хийлдэг бөмбөлөг. Тэгвэл бид нар хөтөлбөрийг үнэхээр хэрэгтэй юм байна гэж мэднэ.
- Бид нартай үйл ажиллагаа явуулж байхдаа **гар утсаараа ярихгүйг хичээгээрэй**, гуйя.
- Бид юм асууж, бас бага сага зүггүйтвэл та бүхэн тэвчээртэй байгаарай. Хэзээ ч битгий хэн нэг хүүхдийг буруутай юм шиг сэтгэгдэл төрүүлж, нийт бүлгийн өмнө битгий зэмлэж байгаарай. Бид нарын алдааг засаж болно. Гэхдээ үүнийг эв дүйтэй, эелдэг хийх хэрэгтэй. Бид нар үе тэнгийнхэн дотроо хүндлэгдмээр байна шүү дээ.

## АФРИКИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ӨГСӨН ЗӨВЛӨГӨӨ, НИГЕРИ УЛС

Жич: хүүхэд, залуучуудын өгсөн доорх зөвлөмжүүдийг насанд хүрсэн идэвхжүүлэгч нэгтгэж оруулсан ...

- Бидэнтэй уулзах газраа сайн бодолцоорой!
- Хүүхэд бүрийн саналыг анхаарч, бид нарын бүх хувь нэмэр хэрэг болох талаас нь хичээгээрэй. Хүүхэд бүрийн санал ач холбогдолтой шүү.
- Тайлбарлахдаа энгийн хялбар англи хэлээр, эсвэл бидний эх хэлээр, бид нарын ойлгодог хэлээр тайлбарлаарай.
- Шаардлагатай бол үзүүлэх аргаар тайлбарлаарай.
- Бүх идэвхжүүлэгч хүүхэд, залуучуудтай ажиллах туршлагатай байх хэрэгтэй.

### Насанд хүрэгсэд тэгш хамрах аргачлалаар ажилладаг байх хэрэгтэй

- Насанд хүрэгсэд бүх хүүхдийн үзэл бодлыг мэдэж авах хэрэгтэй.
- Тодорхой чиглэсэн зорилтот бүлэг бий юу, жишээлбэл өсвөр насны эх эцэг, үндэсний цөөнхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд гэх мэт
- Ямар бүлэг, ямар насны, ямар чадвартай хүүхдүүдтэй ажиллах гэж байна гэдгээсээ шалтгаалж, тухайн бүлэгт аргачлалаа тохируулах хэрэгтэй.
- “Нэг хэмжээ бүгдэд таарна” гэсэн хандлагаар ажиллах нь насны болон нэмэлт хэрэгцээ бүхий хүүхдүүдэд таарахгүй гэдгийг ойлгоно уу. Жишээлбэл, асуумж авахдаа хүүхэд, залуучуудын томоохон бүлгийн ерөнхий саналыг авах гэж байгаа бол бичгийн чадвар муутай бүлгийн хүүхдүүд, асуумж бөглөхдөө бэрхшээлтэй тулгардаг хүүхдүүдэд зохицуулах хэрэгтэй. Зарим сэдвээр чанарын мэдээлэл илүү хэрэгтэй тохиолдолд, жишээлбэл өсвөр насны эцэг эхчүүдэд тохиолддог асуудлууд, орон нутгийн захиргааны халамжид байдаг хүүхдүүдэд учирдаг бэрхшээлийг судлахад фокус бүлгийн ажил тохиромжтой байж болно.
- Хүүхэд, залуучуудтай ажиллахдаа хангалттай хугацаагаар бэлдээрэй.

**ХШҮ–ний арга хэрэгслийг ашиглан хүүхэд, залуучуудтай ажиллахдаа ...**

- Хүүхэд, залуучууд арга хэрэгслийг хэрхэн хамтарч хэрэглэх гэж байгааг Та бүхэнтэй хамтран боловсруулах, тодорхой ойлголттой болох хэрэгтэй байдаг.
- Хүүхэд, залуучуудын оролцооны шаардлагатай цар хэмжээнээс хамаарч наанадаж гурван сарын бэлтгэл үе хэрэгтэй. Жишээлбэл, ХШҮ–ний баг сургууль, орон нутгийн бүлгүүдэд асуумж хэрэглэх гэж байгаа бол өөр өөр насны, өөр өөр чадвартай хүүхдүүдэд тохирсон хувилбар гаргахад хангалттай цаг хугацаа хэрэгтэй.
- Асуумжийн эх хувилбарыг насанд хүрсэн хүн боловсруулж болох ч асуумжийн үг хэллэг, найруулгыг хүүхэд, залуучуудын бүлэгтэй хэлэлцэн зөвлөлдөж засах хэрэгтэй.
- Түүнчлэн хүүхэд, залуучууд оролцох боломжтой гэдгийг хэрхэн зарлахаа бодох хэрэгтэй.
- Хүүхэд, залуучуудад бас сургуулийн амралт, шалгалттай завгүй өдрүүд байдгийг насанд хүрэгсэд санаж анхаарах хэрэгтэй. Сургуулийн амралтын үе нь тоон өгөгдөл цуглуулахад хамгийн тохиромжтой цаг биш боловч сургуулийн амралтад зориулсан үйл ажиллагаа зохион байгуулбал үнэтэй чанарын мэдээлэл авах боломжтой. Гэхдээ танай байгууллагын хүн хүч хязгаарагдмал байж болох тул шаардлагатай мэдээллээ авахад тань бусад байгууллага туслах боломж байна уу гэдгийг судлаарай.
- Нэг зангилаа асуудал бол тухайн дүүрэг, мужийн түвшинд орон нутагт суурилсан бусад байгууллагуудтай холбогдох боломж бий эсэх тухай юм. Зарим байгууллага үйлчилгээгээ хянан үзэх, төлөвлөхдөө хүүхэд, залуучуудтай ажиллах хэрэгцээ гардаг. Гэтэл хүүхэд, залуучуудыг хэт их бичиг цаасаар дарах эрсдэл ч бий. Бусад байгууллагатай хамтарч ажиллавал хүүхэд, залуучуудын амьдралын талаар илүү гүнзгий ойлголт авч болох юм.
- Хүүхэд, залуучуудыг төлөвлөлтийн ажилдаа оролцуулах хэрэгтэй.
- Үйл ажиллагаандаа ашиглах хамгийн оновчтой оролцоот арга юу вэ гэдгийг хүүхэд, залуучуудтай хамтран урьдчилж төлөвлөөрэй.

**Хүүхэд, залуучуудтай дараах зүйлийн талаар зөвлөлдөх хэрэгтэй:**

- **Хаана хамтарч ажиллах:** Хүүхэд, залуучуудтай ажиллаж болох ямар байр, орон зай олдохоор байна? Тэр газар нь хүүхэд очих боломжтой юу? Хүүхдүүдэд ямар унаа хэрэгтэй болох вэ? Хүүхэд, залуучуудтай ажиллахад ямар тоног төхөөрөмж хэрэг болох вэ (жишээлбэл проектор, хэвлэмэл материал гэх мэт)? Тухайн орчин дахь аюулгүй байдал хир зэрэг вэ? Тухайн газар хүүхэд, залуучуудад ээлтэй газар мөн үү? Өрөөний зохион байгуулалт ямар вэ, хир зэрэг тохитой вэ? Хангалттай халаалт, гэрэлтүүлэгтэй юу, амралтын өрөө нь ямар вэ?
- **Оролцоот ажиллагааны мөрөөр хэрхэн ажиллах, хэрхэн эргэн мэдээлэх талаар:** Хэрхэн эргэн мэдээлэл өгөх, хэнд, хэзээ өгөх вэ? Урт хугацааны төслийн хувьд тухайн үйл ажиллагааны үр дүн тогтвортой юу? Үйл ажиллагааны үнэлгээг яаж хийх вэ? Мэдээлэл хаана, ямар хэлбэрээр очих вэ?

**Хүүхэд, залуучуудын бүрэн оролцоог хангахын тулд насанд хүрэгсдээс юу хэрэгтэй вэ:**

- **Хариуцлага:** Бид нар хариуцлагатай гэдгээ Та бүхэнд харуулах боломж олгоорой.
- **Хүндэтгэл:** Та өөртөө хэрхэн хандаасай гэж хүсдэг вэ, бид нарт ч бас тэгж хандаарай.

- **Итгэл:** Бид нарыг хүүхэд учраас л шүүмжлэлтэй битгий хандаарай.
- **Бид нарт боломж олгоорой:** Алдаа гаргаж, туршлагаасаа суралцах, санал бодлоо, тухайн өгүүлэмж дэх өөрийн байр сууриа тайлбарлах боломж олгоорой.
- **Бид нарт анхаарал халамж тавиарай:** Та бүхэн бид нарт анхаарал халамж тавьж байна гэдгээ ойлгуулаарай.
- **Бид нарыг дэмжиж байгаарай:** Бид нар зөв юм хийсэн гэдэгтэй итгэлтэй байх хэрэгтэй байдаг.
- **Ойлгох:** Бид нарын хэлж байгааг анхааралтай сонсож, бид нарт ч гэсэн сэтгэлийн зовуурь, хүнд асуудлууд байдгийг ойлгоорой.
- **Тэнцвэр:** Бид нарыг тэр чигээр нь битгий орхиорой, бид нар унавал түшээд авах насанд хүрэгсэдтэй байх хэрэгтэй.
- **Биднийг сайшааж байгаарай:** Хэрэв бид нар сайн зүйл хийж байвал, зөв шийдвэр гаргаж байвал сайшааж байгаарай.
- **Эрх чөлөө:** Хэцүү байлаа ч биднийг зөнд нь орхиорой. Бид нар өөрийн гэсэн замтай, өөрсдийнхөөрөө шийдвэр гаргаж, алдаагаа үүрэх тавилантай. Бид нар өөрсдөө хэн бэ, бид нарын үнэт зүйл юу вэ, бие хүний хувьд бид нарт юу хэрэгтэй вэ гэдгээ олж мэдэх нь хүн болж өсөхийн нэг хэсэг.

Гана Улс дахь Дэлхийн Зөн байгууллага болон Африкийн Хөдөлмөр Эрхэлдэг Хүүхэд Залуучуудын Хөдөлгөөний хүүхэд, залуучууд Нигери Улсад уулзаж, насанд хүрэгсдийг хүүхэд, залуучуудтай хэрхэн ажиллаасай гэж хүсдэг талаараа зөвлөмж боловсруулсан ...

**Бид нарт таалагддаг ...**

- Насанд хүрэгсэд бид нарын үзэл бодлыг хүндэтгэж байвал
- Насанд хүрэгсэд бид нарыг үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрч байвал
- Насанд хүрэгсэд бид нарын илэрхийлж байгаа санал бодлыг хүндэтгэж байвал
- Бид нарын мэддэггүй зүйлд үргэлжүүлэн тусалж байвал
- Насанд хүрэгсэд бид нартай эн тэгш эрхтэй оролцож байвал
- Бид нартай хүүхдэд ээлтэй арга хэлбэрээр харилцаж байвал
- Насанд хүрэгсэд бид нартай ширүүн, муу харьцахгүй байвал.

**Бид нарт таалагддаггүй ...**

- Багш, эцэг эхчүүд бид нарыг хичээлээ уншиж байхад үймүүлж тасалдуулахад
- Насанд хүрэгсэд хүүхдэд ялгавартай хандахад (бүх хүүхдэд тэгш хандах хэрэгтэй)
- Бид нар санал бодлоо илэрхийлж байхад бидний дууг хориход
- Хүүхдэд хэцүү ачаа үүрүүлэхэд
- Засгийн газар сургуулийн хүүхдүүдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байхад
- Хүүхдэд муу хандахад
- Орон нутгийн удирдагчид шийдвэр гаргах үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулахгүй байвал.

Нэг оролцогч дээрх асуудлуудын заримыг нэгтгэсэн зохиомж боловсруулсан:

Нэгэн охин хойд ээж нь авдартай өндгийг зах руу аваад яв гэсэн тул шалгалтандаа бэлдэж хичээлээ уншиж чадахгүй болжээ. Авдартай өндөг авч явах охинд маш хэцүү хүнд байсан тул замдаа алдаад унагачихажээ. Түүнийг “тэнэг охин” гэх мэтээр айхавтар харааж загнасан байна.

Өөр нэгэн зурагт насанд хүрэгсэд хүүхдийг шийдвэр гаргах ажиллагааны гадна үлдээсэн байна.

Бас нэг оролцогч хүүхэд жүжигчилсэн тоглолтын зохиомж бичиж бусад оролцогч хүүхдүүд түүнийг нь тоглосон. Жүжигт их цэвэрлэгээ хийе гэсэн хүүхдүүдийн саналыг насанд хүрэгсэд сонсоогүйгээс тосгоноороо булчин задрах тахалд нэрвэгдэж байна.

Нигери Улсын хүүхэд, залуучууд цуврал зураасан зураг зурсан. Уг цуврал зурагт хүүхдүүд ядарч сульдсан үедээ амрах хэрэгтэй, байнга ажиллуулаад байж болохгүй гэдгийг үзүүлсэн байна.

### ӨВЧТЭЙ ҮЕДЭЭ АМРАХ ЭРХТЭЙ





# ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДҮГНЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭРЭГСЛҮҮД

ТОВХИМОЛ

6

ХҮҮХДИЙН ОРОЛЦООНД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ 10 АЛХАМТ ЗААВАР

Арга хэрэгслийн багц нь хүүхдийн оролцоог хэмжих үзэл баримтлалын үндэслэл, ХШҮ хийх удирдамж, шаардлагатай мэдээллээ авахад хэрэглэх арга хэрэгслүүдийг багтаасан. Шууд хүүхэдтэй ажилладаг байгууллагууд, хүүхдийн удирдлагатай, залуучуудын удирдлагатай байгууллагууд, хүүхдийн оролцох эрхийг хангах үүргээ хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа төрийн байгууллагууд энэхүү арга хэрэгслийн багцыг хэрэглэж болно.

Арга хэрэгслийн багц зургаан товхимлоос бүрдэнэ. Үүнд:

**Товхимол 1–д** арга хэрэгслийн багцын тухай үндсэн мэдээлэл, хүүхдийн оролцооны тойм мэдээлэл багтсан. Мөн ХШҮ–ний товч удирдамж, гол нэр томъёолол, холбогдох эх сурвалжуудын мэдээллийг агуулсан.

**Товхимол 2–г** тухайн улс орон, нөхцөл байдалд хүүхдийг хүндэтгэх, хүүхдийн оролцоог хангах орчин бүрдсэн байдлыг хэмжих суурь, хэрэгжүүлэх арга замыг заасан. Үүнд:

а) оролцох эрхийг хамгаалах; б) оролцох эрхийг сурталчлан таниулах; в) оролцох орон зай бий болгох.

**Товхимол 3–г** аливаа орчинд хүүхдийн оролцооны цар хүрээ, чанар, үр дүнг хэмжих үзэл баримтлалын суурийг танилцуулна. Түүнчлэн хүүхдийн оролцоонд ХШҮ хийх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилготой жишиг хэмжүүрүүд болон матрицуудыг үзүүлнэ.

**Товхимол 4–г** оролцоот ХШҮ–ний үйл ажиллагааг хүүхдүүд болон бусад оролцогч талуудтай хэрэгжүүлэх 10 алхамт удирдамж багтсан. Түүнчлэн зорилго, зорилтуудаа хэрхэн томъёолох, явц ахицыг хэмжих үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлох, цэгцтэй өгөгдөл цуглуулах, баримтжуулах, ХШҮ–ний мэдээлэлд дүн шинжилгээ хийх удирдамжийг оруулсан.

**Товхимол 5–д** хүүхдийн оролцооны чанар, цар хүрээ, үр дүнд ХШҮ хийх зорилгоор хүүхэд, залуучуудтай болон бусад оролцогч талуудтай ажиллахад тохиромжтой арга хэрэгслүүдийг оруулсан. Зарим арга хэрэгслийг Товхимол 3 дахь матрицтай холбоотой мэдээлэл цуглуулахад зориуд тохируулсан байгаа.

**Товхимол 6** нь арга хэрэгслийн багцыг туршин хэрэгжүүлэхэд оролцсон хүүхэд, залуучуудын бүтээл юм. Үүнд хүүхдийн оролцооны ХШҮ–ний ажил хийхдээ санах зүйлсийн талаар насанд хүрэгсэд, хүүхэд, залуучуудад зориулсан удирдамж орсон билээ.

